



**ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ**

2026 оны 08 сарын 13 өдөр

Дугаар 101

Улаанбаатар хот

Нээлттэй сонгон шалгаруулалтын баримт бичиг батлах тухай

Зөвшөөрлийн тухай хуулийн 5.6 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.6 дахь хэсэг, 30 дугаар зүйлийн 30.1.10 дахь заалт, Радио долгионы тухай хуулийн 5¹ дугаар зүйлийн 5¹.1.2, 5¹.1.11 дэх заалт, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2026 оны 76 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Монгол Улсын нутаг дэвсгэрт олон суваг дамжуулах үйлчилгээ (интернэт протоколд суурилсан /OTT/) эрхлэх тусгай зөвшөөрөл олгох нээлттэй сонгон шалгаруулалтын баримт бичгийг нэгдүгээр, Говь-Алтай, Говьсүмбэр, Дорноговь, Дундговь, Сэлэнгэ аймгийн нутаг дэвсгэрт Өргөн нэвтрүүлгийн телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох нээлттэй сонгон шалгаруулалтын баримт бичгийг хоёрдугаар, Говь-Алтай, Говьсүмбэр, Дундговь, Сэлэнгэ аймгийн нутаг дэвсгэрт Арилжааны телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох нээлттэй сонгон шалгаруулалтын баримт бичгийг гуравдугаар, Баян-Өлгий, Баянхонгор, Булган, Говьсүмбэр, Дорноговь, Дундговь аймагт арилжааны радиогийн үйлчилгээ эрхлэх, радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах тусгай зөвшөөрөл олгох нээлттэй сонгон шалгаруулалтын баримт бичгийг дөрөвдүгээр хавсралт ёсоор тус тус баталсугай.

2.Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан сонгон шалгаруулалтыг зохион байгуулах, үр дүнг танилцуулахыг Харилцаа холбооны зохицуулах хорооны дарга Ж.Бат-Эрдэнэд үүрэг болгосугай.

ДАРГА

Ж.БАТ-ЭРДЭНЭ

ГИШҮҮД

Б.АНХБААТАР

Ц.ГАНЗОРИГ

Б.ДАГВАСҮМБЭРЭЛ

Ч.ЗОЛБАЯР

С.ТАМИР

А.ҮЙЛСТӨГӨЛДӨР